



ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ТАМГЫН ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ

2021 оны 03 сарын 24 өдөр

Дугаар А/29

Ховд

Үнэлгээний хороо байгуулах тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.1.1 дэх заалтыг үндэслэн ТУШААХ нь:

1. Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар хийгдэх Цэвэр, бохир усны шугам сүлжээний зураг, төсөв /Наран баг/ гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах үнэлгээний хороог дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Дарга: Д.Ариунбилэг - Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын хэлтсийн дарга

Гишүүдэд: З.Мөнхтуул - 9 дүгээр цэцэрлэг нягтлан бодогч
Ц.Нямдаваа - Төрийн бус байгууллагын төлөөлөл
Ц.Соёлмаа - Иргэний төлөөлөл

Нарийн бичгийн дарга: Б.Болор-Эрдэнэ - Орон нутгийн өмчийн газрын нягтлан бодогч

2. Үнэлгээний хорооны гишүүдээс ашиг сонирхолын зөрчилгүй гэдгээ илэрхийлэх, зөрчил үүссэн тухай мэдэгдэл авах, тендер шалгаруулалтыг хууль тогтоомжийн дагуу зохион байгуулан явуулж үр дүнг танилцуулахыг Үнэлгээний хороо /Д.Ариунбилэг/-нд даалгасугай.

3. Дээрх төсөл арга хэмжээний худалдан авах ажиллагаатай холбоотой бүх баримт бичгээр хадгаламжийн нэгж үүсгэхийг Үнэлгээний хорооны нарийн бичгийн дарга /Б.Болор-Эрдэнэ /-д үүрэг болгосугай.

ДАРГА



Д.ЭНХБОЛД